



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 340

Улаанбаатар хот

Г “Ремикон” ХК-ийн хаалттай хүрээнд санал 7
болгон нэмж гаргаж буй хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7 дугаар зүйл, 34.1.7, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл, “Ремикон” ХК-ийн 2011 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус хувь нийлүүлэгчдийн хурлын 05/5 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ремикон” ХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргасан энгийн хувьцааны тоог нийт 39,460,000/гучин есөн сая дөрвөн зуун жаран мянга/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн үнэт цаасны бүртгэлд нэмж бүртгэн, тус компанийн нийт хувьцааг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 118,139,464/нэг зуун арван найман сая нэг зуун гучин есөн мянга дөрвөн зуун жаран дөрөв/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/-т үүрэг болгож, Хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан нэмж гаргаж буй энгийн хувьцааг хавсралтад дурдсан хуулийн этгээдүүдэд худалдахаар санал болгохыг зөвшөөрсүгэй.

3. Тус компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаар шийдвэрлэсний дагуу дээрх нэмж гаргаж буй энгийн хувьцааг компанийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй

4. Нэмж гаргаж буй энгийн хувьцааг хаалттай хүрээнд санал болгох доод үнийг 190/нэг зуун ер/ төгрөгөөр тогтоохыг зөвшөөрсүгэй.

5. Нэмж гаргаж буй хувьцааг хаалттай хүрээнд худалдан авахыг санал болгох ажиллагааны дүнд төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай 7,497,400,000/долоон тэрбум дөрвөн зуун ерэн долоон сая дөрвөн зуун мянга/ төгрөгийн 80-аас доошгүй хувийг төвлөрүүлж

чадсан нөхцөлд үнэт цаасыг хаалттай худалдах ажиллагааг амжилттай болсонд тооцохоор тогтсугай.

6. “Ремикон” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж дууссаны дараа Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хоёрдогч зах зээлийн арилжааг нээхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/-д үүрэг болгосугай.

7. Тус компанийн нэмж үнэт цаас гаргах шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Ремикон” ХК/Э.Мөнхсайхан/, “Фронтнер” ХХК/Игата.М/-д тус тус үүрэг болгосугай:

1/ тус компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаас нэмж үнэт цаас гаргах шийдвэр гаргасантай холбогдуулж нийт хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа компанид эргүүлэн худалдахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг ажлын 10 хоногт багтаан тус Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлэх;

2/ нэмж гаргасан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдсанаас хойш ажлын 5 хоногт багтаан компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг холбогдох баримтын хамт Хороонд ирүүлэх.

8. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Ремикон” ХК/Э.Мөнхсайхан/-д үүрэг болгосугай.

9. Үнэт цаасыг хаалттай хүрээнд санал болгон худалдах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд үнэт цаас худалдсаны орлого буюу үнэт цаас гаргагч “Ремикон” ХК-ийн дансанд байршсан мөнгөн хөрөнгийг тус компани хувь нийлүүлэгчдийнхээ хурлыг шинэчилсэн бүрэлдэхүүнтэйгээр зарлан хуралдуулж, төслийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг захиран зарцуулах болон удирдлагын бүтцэд өөрчлөлт орох талаар холбогдох шийдвэрийг гаргаж тус Хороонд ирүүлэх хүртэл хугацаанд тусгаарлахаар тогтсугай.

10. Энэ тогтоолын 9-д заасан мөнгөн хөрөнгийг тусгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Хорооноос зөвшөөрсөн тохиолдолд тусгаарлалтаас чөлөөлөхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК/Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

11. “Ремикон” ХК-ийн хаалттай хүрээнд нийтэд санал болгон худалдсан үнэт цаасыг худалдан авсан хувьцаа эзэмшигчдийн тус компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцох эрхийг хангах зорилгоор Хорооны 2008 оны 141 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат

компанийн хурлын зар мэдээг хүргэх тухай журам”-ын 2.6 дахь заалт нь тус компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг зохион байгуулахад үйлчлэхгүй болохыг тогтоож, хувь нийлүүлэгчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах “бүртгэлийн өдөр”-ийг хувь нийлүүлэгчдийн хурал хуралдах өдрийн өмнөх өдөр байхаар тогтоосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

1. INVESCO
2. S.A.C CR Intrinsic Investors
3. Platinum Advisory International Inc.
4. M Capital Investment Management Limited
5. BANZ ASIA LIMITED
6. QUANTUM PEAK INVESTMENT LTD
7. BOCI- PRUDENTIAL ASSET MANAGEMENT LIMITED
8. NOAH ARK INTERNATIONAL
9. CCB INTERNATIONAL
10. KHAN INVESTMENT MANAGEMENT LIMITED
11. PRAETORIAN CAPITAL
12. GENII CAPITAL
13. MONGOLIA BUSINESS CLUB
14. H de P ALTERNATIVE SA
15. SAC GLOBAL
16. LOTUS RENAULT GP LIMITED
17. LIONGATE
18. EMIRATES NBD
19. TIAA CREF
20. VILLAGE CAPITAL
21. MARTIN CURRIE
22. STROUT CAPITAL
23. LAZARD ASSET
24. MT LABO
25. PALTON
26. SIMPLEX
27. SBI
28. OECHSLE
29. FAR EAST GROUP
30. ZETLAND CORP
31. CHUANG'S CONSORTIUM
32. FVP
33. TAI TAM COMPORATION
34. TEMPLETON ASSET MANAGEMENT
35. NORDEA